

## 2023-2024 ОНЫ 4-Р АНГИЙН МОНГОЛХЭЛНИЙ АНГИ ДЭВШИХ

## ШАЛГАЛТЫН СЭДЭВ

## А вариант

Нийт 24 оноо

НЭГ. Эхийг анхааралтай ойлгож уншаад, асуултанд хариулан, даалгавруудын хариултаас зөвийг сонгоно уу.

## Цоорхой хувин

Эрт урьд цагт Энэтхэгийн нэгэн ус түгээгч хоёр хувинтай дамнуургаар ус зөөдөг байжээ. Харин хоёр хувингийн нэг нь цоорхой бөгөөд усных нь тал нь асгарчихаад хүрдэг байв. Энэ байдлаасаа цоорхой хувин ихэд ичиж, харин бүтэн хувин нь өөрөөрөө бахархдаг байв. Иймэрхүү байдлаараа бүтэн хоёр жил үргэлжилж, эцэст нь цоорхой хувиг тэсч чадалгүй:

-Эзэнтэн минь би өөрөөсөө ихэд ичиж байна. Мөн танаасаа уучлалт гуйхыг хүсч байна гэжээ.

-Яагаад? гэж усчин асуухад:

-Яагаад гэвэл би авч ирэх ёстой усныхаа дөнгөж талыг нь авчирдаг. Тэгээд та миний ийм байдлаас болж авах ёстой мөнгөө бүгдийг нь авч чаддаггүй шүү дээ гэхэд усчин хариуд нь:

-Чи буцах замдаа замын хажуу талын цэцгүүдийг хараарай гэв. Цоорхой хувин буцахдаа замаа хартал үнэхээрийн сайхан цэцгүүд ургасан байлаа. Гэсэн хэдий ч хүрэх газраа ирэхэд бас л тал устай байсан тул усчнаас уучлал гуйв. Тэгэхэд усчин цоорхой хувингаасаа:

-Замын хажууд зөвхөн чиний талд л цэцгүүд ургасан, харин нөгөө хувингийн талд цэцэг ургаагүй байгааг ажиглав уу? гэж асуугаад:

-Үүний учир нь чамайг цоорхой болохоор замын хажуугаар цэцгийн үр суулгасан юм. Ус аваад буцах замдаа чи тэднийг усалж сайхан цэцгүүд ургуулсан. Хоёр жилийн турш би энэхүү цэцгүүдийг түүж эзнийхээ гэрт тавьдаг байсан. Хэрвээ энэ цэцгүүд байгаагүй бол түүний гэрт аз жаргал авч ирэхгүй байсан шүү дээ хэмээн өгүүлжээ.

1. Цоорхой хувинтай талд сайхан цэцгүүд ургасан нь юутай холбоотой вэ? \1 оноо\

- А. Усчин цэцгийн үр суулгасан.
- Б. Ус үргэлж гоождог байсан.
- В. Салхин дээд талд байсан.
- Г. Замын хоёр талд адилхан ургасан.

2. Цоорхой хувин яагаад өөрөөсөө ичсэн бэ? \1 оноо\

- А. Авч ирэх ёстой усныхаа талыг авч ирдэг.
- Б. Бүтэн хувин шоолдог байсан.
- В. Эзэн нь уурладаг байсан.
- Г. Ус огт тогтдоггүй байсан.

3. Бүтэн хувин, цоорхой хувин хоёрын ялгаа нь юу вэ? \1 оноо\

- А. Бүтэн хувин ухаантай, цоорхой хувин онгиороо
- Б. Бүтэн хувин бардам, цоорхой хувин онгиороо
- В. Бүтэн хувин сагсуу, цоорхой хувин бардам
- Г. Бүтэн хувин бардам, цоорхой хувин ухаантай

4. Ж, Ч, Ш -ийн дүрмээр бичигдсэн үгийг олоорой. \1 оноо\

А.тамир б. Чимээ в. Ширдэг г.Хашир

5.Цэцэг айл гэрт аз жаргал авчирдгийн учир юунд байна вэ? Бодлоо бичнэ үү?  
\1 оноо\

6.Үгсийг тохирох дүрэмтэй нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.\1оноо\

- 1.Мордьё а.Гийгүүлэгчээр төгссөн эм үгэнд е залгахдаа ь бичиж тусгаарлана.
- 2.Хоноё б.Гийгүүлэгчээр төгссөн эр үгэнд “я, ё “залгахдаа “ь”тусгаарлана
- 3.Мэдье в.Эгшгээр төгссөн үгэнд “е, ё, я “ шууд залгана.
- 4.Зорьё г. Ъ тэмдгээр төгссөн үгэнд “я е, ё” шууд залгана.

А. 1а 2б 3в 4г Б.1б 2в 3в 4 а В. 1б 2в 3а 4г Г:1а 2в 3а 4б

7. “Тэмээ туйлсан юм шиг” хэлц үгийн утыг зав тайлбарлан бичээрэй. 1 оноо

8. Балархай эгшигийн үүргийг зөв хараглзуулаарай. 1 оноо

А.хүрэм-ялгах

Чанар- эгшигжүүлэх

9. Бяцхан үгийн ойролцоо үг нь аль үг вэ.

А. Жаахан Б. Том В. Өхөөрдөм Г. Хөөрхөн

10. цоорхой хувин гэж ямар хувинг хэлэх вэ?

Хоёр: БИЧИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР

1 Урилганы загварыг гүйцээн бичээрэй. \2оноо\

1..... 2.....

3.Хэзээ хаана ирэхийг бичнэ. 4.Хэн ирсэн болохыг бичнэ.

2. Дараах үгийн утгыг гарган, өгүүлбэр зохиогоорой. 3 оноо

Хуул.....

Хуйл.....

Хууль.....

3. Дараах хэлцээр өгүүлбэр зохион бичээрэй. 2 оноо

4. Я,е,ё залгаврыг залган бичихдээ зөв бичих дүрмийг тайлбарлаарай. 2 оноо

Магнай тэнийх.....

2. Сургуулийнхаа сурагчдад хандан хоггүй орчинд амьдрах тухай уриалга  
бичээрэй.Үгийн тоо \50-60\ \5 оноо\

## 2023-2024 ОНЫ МОНГОЛХЭЛНИЙ АНГИ ДЭВШИХ

## ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Б вариант

24 оноо

НЭГ. Эхийг анхааралтай ойлгож уншаад, асуултанд хариулан, даалгавруудын хариултаас зөвийг сонгоно уу

## Дэлбээт цэцэг

Нэг шидтэн хүүд 5 дэлбээтэй хүсэл биелүүлэгч цэцэг өгчээ. Цэцэгнээс дэлбээг таслах бүрд чиний нэг хүсэл биелнэ гэжээ. Гэхдээ чи сайн үйлийг хийгээрэй гэв. Хүү их баярлаж, юу хүсэхээ бодсон ч үгүй хамгийн сайхан чихэр, бялуу гээд амттан бүрийг хүсжээ. Хүсэл нь дороо л биеллээ.

Дараа нь хүү дэлхийн хамгийн зугаатай тоглоомыг хүсэхэд хүсэл нь бас л биелжээ. Хүү ч улам баярлан, элдвийг хүссээр ганцхан дэлбээ үлдээд, юу гуйснаа бодож, түүний гуйсан зүйл тийм ч хэрэгтэй биш байсныг ухаарчээ. Хамгийн сүүлд юу гуйхаа бодож гэнэ.

Энэ бүх үед ганцаараа байснаа бодож, хамт тоглох найз хайтал түүний ойролцоо нэг охин уйтгарлан сууж байхыг хараад, хамт тоглоё гэсэнд тэр “Миний хөл муу. Би гүйж тоглож чаддаггүй” гэж гуниглан хэлсэнд хүү, охиныг өрөвдөж, хамгийн сүүлийн дэлбээгээ “Тэр охины хөлийг эдгээж өгөөч” гэж хүсэж тасаллаа. Хүү олон дэлбээг сайн үйлд зориулаагүйдээ харамссан ч сүүлийн дэлбээгээрээ охинд аз жаргал бэлэглэсэндээ их л баярлажээ.

1. Шидтэн хүүд юу гэж захисан бэ?
  - А. Сайн үйлийг хийгээрэй
  - Б. Хүссэн бүхнээ аваарай.
  - В. Дэлбээт цэцгээ хадгалаарай.
2. Хүү юунд харамссан бэ?
  - А. Сайн үйлд зориулаагүйдээ
  - Б. Чихэр, бялуу их авч чадаагүйдээ
  - В. Хамгийн зугаатай тоглоом хүссэндээ
3. Хүү сүүлийн дэлбээгээ таслахдаа юу хүссэн бэ?
  - А. Шинэ дугуй
  - Б. Охины хөлийг эдгээж өгөөч
  - В. Амттай бялуу
  - Г. Юу ч хүсээгүй
4. Шидтэн хүүд юу өгсөн бэ?
  - А.Таван навч
  - Б.таван дэлбээт цэцэг
  - В.таван дэлбээ
5. Хүү юунд баярласан бэ?



.....

.....

.....

.....

..

4а ангийн сурагч.....